

*Ерөнхий хэсэг*

## МОНГОЛЫН ГЕОЛОГИЙН САЛБАРЫН ТҮҮХИЙГ БҮТЭЭЛЦСЭН ЖИРИЙН ГЕОЛОГЧИД

Ө.ЖАМЪЯНДОРЖ<sup>1</sup>, Ж.БЯМБА<sup>2</sup>

Геологийн судалгааны төв<sup>1</sup>  
Монгол Улсын Их Сургууль<sup>2</sup>

*Түлхүүр үг: Монголын Геологийн судалгаа, түүх*

Монгол улсад эрдэс баялагаа судалдаг төрийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн түүхт ойг тэмдэглэж байгаа энэ үед түүчээ хүмүүсээ дурьдахын ялдамд манай орны геологийн судалгааны түвшин ямар байдалд байсныг бид томчхон боловч эргэн санах нь зүй хэрэг гэж бодож байна.

Тухайлбал: В.А.Обручев, Д.А.Клименц, А.А.Чернов, М.А.Усов, Н.И.Толстихин зэрэг Оросын олон геологч-эрдэмтэд түр хугацаагаар ажиллаж тус улсын нутаг дэвсгэрт кембрийн өмнөх ба палеозойн настай зузаалаг, мезо-канозойн цаг үеийн хурдас хуримтлалын ба палеонтологийн үлдвэрийн талаар олон тооны мэдээлэл цугларсан байна.



**В.А.Обручев**  
(1963-1956)

Зөвлөлтийн ШУ-ны Академич В.А.Обручев Төв Азийн геологи-газарзүйг судлахын хамт Монголын геологийн судалгааны үндсийг тавигчийн нэг байсан юм. Түүний олон талт судалгааны нэг хэсэг нь мөнхцэвдэг, лесс, Сибирийн ба Дорнод Монголын геологийн судалгаанд чиглэгдэж байв.

Ардын засгийн анхны жилүүдэд 1923 онд судар бичгийн хүрээлэнд геологийн тасаг ажиллуулж байснаас гадна 1923 онд Зөвлөлтийн ШУА-ын дэргэд И.П.Рачковскийгоор удирдуулсан Монголын комисс гэж байгуулагдсан.

Энэ ажилд З.А.Лебедева, П.П.Сизова, М.Ф.Нейбург, В.И.Крыжановский, Б.М.Куплетский, В.А.Смирнов, К.А.Ненадкевич, А.Л.Смольянинов нарын зэрэг эрдэмтэд оролцож байжээ.

1931 оноос Монгол улсад Дорнодын геологийн экспедиц хэмээх ашигт-малтмалын эрэл-үнэлгээний ба талбайн эрэл-зураглалын ажил хийх байгууллагын үйл ажиллагаа эхэлсэн билээ.

Энэ бүгд нь 1939 он гэхэд тус улсын үйлдвэрлэлийн геологийн судалгааны үндэс баттай тавигдаж түүнийг төрөөс удирдах төв байгуулага шаардлагатай болсон юм.

Одоо бид ойг нь тэмдэглэж байгаа энэ 70 жилд Монголын геологийн судалгаанд бага ч болов хувь нэмрээ оруулж ирсэн анхдагчидаа дурсан саная.

Монголын Геологийн албаны 70 жилийн түүхэнд олон үйл явдал болжээ.



**И.П.Рачковский**

(1878-1961)

Доктор (Sc.D) тэрбээр ЗХУ-аас Монголд ажилласан анхны геологийн эрдэм- шинжилгээний экспедицийн дарга бөгөөд түүний судалгаа нь Тува, Баруун Монголын нутаг дэвсгэрийн стратиграфи, тектоникийн хөгжил ба ашигт малтмалын зүй тогтлыг хамарч байв.

Тэдгээрийн түүчээ буюу анхдагчийн тухай өгүүлэхдээ түүх тасралтгүй үргэлжилдэг болохоор түрүүч болон дараач үеийнхнийх нь талаар бас дурдлаа.

Эндээс монголын геологийн салбарын түүхийг бидний дунд ажиллаж амьдарч байсан жирийн хүмүүс бүтээж ирсэн бэлэнхээ харагдах болно.

Манай ууган геологч нь Москвагийн геологи-хайгуулын дээд сургуулийг 1938 онд төгссөн Жалцавын Дүгэрсүрэн юм. Тэрээр геологч болсныхоо дараа Өмнөговь, Дорноговь, Баянхонгор зэрэг аймгийн нутаг дахь нүүрс, Зүүнбаянгийн нефтийн ордыг нээж эрэл-хайгуулын ажилд оролцож байжээ.

Мөн Ленинград хотноо суралцаж 1939 онд төгссөн Шалоны (Чулууны) Цэвэг манай ууган геологчдын нэгд зүй ёсоор орно Тэрээр ШУА-ийн геологийн тасагт эрдэм шинжилгээний ахлах ажилтнаар ажиллаж Өмнөговь, Өвөрхангай, Дорноговь, Хэнтий, Төв зэрэг аймгуудын нутгаар эрэл шалгалтын ажлаар явж 12 тайланг орос, монгол хэл дээр бичсэнээс гадна “БНМАУ-ын ашигт малтмалын тухай эмхэтгэл” ном, геологийн шинжлэх ухааны 10-аад өгүүлэл, орчуулга, Монгол-Орос (Лувсандэндэв, Наваан-Юндэн нарын хамт), Монгол-Герман толь бичгийг зохиосон манай улсын боловсролтой сэхээтний нэг байлаа. 1940-өөд оны сүүлчээр геологийн шинжлэх ухааныг сурталчлах зорилгоор В.А.Обручевын “ Уул ба эх газрын тогтол” (1949), Толстихин, Маринов нарын “Монголын рашаан” (1948) зэрэг ном, марганец, вольфрам, цагаан тугалганы ордуудыг хайх тухай товхимолыг орчуулсны зэрэгцээ “Глаберын давс” (1948), “Ашигт малтмалын орд эрэгчдэд өгөх аюулгүйн зөвлөлгөө” (1966), “Геологийн нэр томъёоны товч тайлбар толь” (1966) зэрэг бүтээл туурвижээ.



**Ж.Дүгэрсүрэн**

(1909-1986)

Доктор (Sc.D) Ж.Дүгэрсүрэн бол Монголын анхны геологч бөгөөд тус улсын шинжлэх ухаан ба геологийн дээд боловсролыг зохион байгуулж бэхжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулжээ. Тэр бээр гидрогеологи, шатах ашигт малтмалын чиглэлээр ажиллаж нүүрс, шатах занар, газрын тос, метал бус ашигт малтмалын хэдэн арван орд, илрэл нээсэн эрдэмтэн юм.

Мөн тэрээр Монголын анхны геологийн зурагт (1957) зохиогчоор оролцжээ.

Монголын геологийн алба байгуулагдсан цагаасаа эхлэн эхний ээлжинд жижиг масштабын (1:1000 000 ба 1:500 000) геологийн зураглалаар нутгаа бүрхэхээс гадна ашигт малтмалын ирээдүй бүхий талбайнуудад дунд (1:200 000) болон том (1:50 000) масштабын эрэл-зураглалын ажлыг зэрэгцүүлэн хийж байжээ. Тухайлбал, 1939-40 онд Баруун Монголд 1:1 000 000-ны масштабын (И.Я.Мирская нар), 1940 онд Өвөрхангайд 1:500 000-ны масштабын (С.Н.Алексейчик нар), 1943 онд Хэнтийд 1:200 000 –ны

масштабын (С.Н.Алексейчик нар), 1947 онд Мөрөн ба Цэнхэр голын районд 1:50 000-ны масштабын (Н.И.Хомизури нар) зураглал хийсэн нь талбайн анхны зураглалын ажлууд байсан бөгөөд системтэй судалгааны эхлэл болжээ.

1941 онд Зүүнбаянгийн нефтийн хайгуулд Далантүрүү гэдэг газар “Крелиус” маркийн баганат өрөмдлөгийн анхны цооногийг өрөмджээ.

Үүнээс өмнө манайд Налайх зэрэг нүүрсний болон алтны ордуудыг хайж шинжлэхэд “Эмпаир” маркийн морины хүчээр ажиллах өрөм ашиглаж байсан ба цохилтот өрмийг Мал ба газар тариалангийн яамны шугамаар ус гаргахад хэрэглэж байжээ.

1946-49 онд Зөвлөлтийн нэрт судлаач, зөгнөлт зохиолч И.А.Ефремовын удирдсан палеонтологийн экспедицийнхэн Өмнөговь аймгийн Нэмэгтийн өвөр хөндийд үлэг гүрвэл (динозавр), эртний хөхтөн, яст мэлхий, матар, чулуужсан өндөг зэрэг олон төрлийн амьтны үлдвэрийг анх нээн судалсан нь Монгол орны палеонтологийн олдворыг дэлхий дахинд алдаршуулсан билээ.



**И.А.Ефремов**  
(1907-1972)

Доктор (Sc.D) тэрбээр Монголд ЗХУ-аас 1946-1949 онд анх зохин байгуулагдсан палеонтологийн экспедицийг толгойлон ажиллажээ. Энэ экспедицийн явцад Төв Азийн үүний дотор Монголын мезокайнозойн үлэг гүрвэл, сүүн тэжээлтний баялаг олдворыг судлаж тухайн цаг үеийн эртний газарзүйг сэргээхэд чухал хувь нэмэр оруулсан.

Одоогоос 60-70 сая жилийн өмнө амьдарч байсан 5-5,5 м өндөр, 10-12 м урт үлэг гүрвэлийн хэлхээ яс, түүний чулуужсан өндөг, арслан зааны яс зэрэг олон сонин үзмэр Байгалын түүхийн музейд хадгалагдаж байна.

Геофизикийн аргыг анх 1948 онд нефтийн эрэл хайгуулын ажилд хэрэглэжээ. Геофизикийн судалгааг 1963 оныг хүртэл зөвлөлтийн мэргэжилтнүүд хийж байлаа.

1963 онд Геологи шинжилгээний газрын харьяанд геофизикийн анги байгуулагдсанаар үндэсний геофизикийн албаны суурь тавигдсан бөгөөд монгол мэргэжилтнүүд ажиллаж эхэлжээ.

1960-аад оны дундуур Монгол орны төв ба дорнод хэсэгт 1:200 000-ны масштабын агаарын соронзон болон гравиметрийн зураглалыг 550 гаруй мянган кв. км талбайд хийсний зэрэгцээ нарийвчилсан агаарын геофизикийн (соронзон, радиометр) судалгааг зарим газруудад явуулжээ.

Эдгээр ажлын үр дүнд гүний геологийн бүтцийг тусгасан металлогени-структурийн зураг зохиосон нь эрэл зураглалын ажил явуулах талбайг сонгох үндэслэл болсон юм.

1973 оноос тодорхой ашигт малтмалын биеэ даасан эрлийн ажлыг геологи, геохимийн аргуудтай хослуулан 1:10 000-1:25 000-ны масштабтаар ирээдүй бүхий томоохон талбайд гүйцэтгэх болов.

Манай орны гидрогеологийн судалгаа эхэн үедээ малын бэлчээр усжуулахад чиглэгдэн ЗХУ-ын тусламжаар хийгдэж байсан бөгөөд 1965-97 онд 1:500 000-1:200 000-ны масштабтай геологи-гидрогеологийн зураглалыг Их нууруудын хотгор болон Говийн аймгуудын нутгийг хамарсан 450 гаруй мянган кв. км талбайд хийж газар дорхи усны тархалт, бүрдэлтийн зүй тогтлыг тодруулжээ. Тодорхой объектын усан хангамжийг

шийдвэрлэх зорилгоор газар дорхи усны гидрогеологийн эрэл, хайгуулын ажил 1973 оноос эхэлж 150 орчим цэнгэг усны орд илрүүлэн нөөцийг тогтоожээ.

Монгол орны гидрогеологийн зургийг 1:1 500 000-ны масштабээр 1966 онд, 1:1 000 000-ны масштабээр 1997 онд тус тус зохиожээ.

1950-1980 онд Монгол орны хэмжээнд 41 халуун, 60-аад хүйтэн рашааныг судалсан бөгөөд Хужирт, Отгонтэнгэр, Хүрэмт, Шивэртэй, Улаанбаатар, Халзан уул, Жанчивлан, Шаргалжуут, Цэнхэр, Ерөө зэрэгт рашаан сувилал, амралтын газрууд байгуулагджээ.

Багануур дүүргийн орчимд 1991 онд геозкологийн тойм судалгаа хийсэн нь энэ чиглэлийн талбайн төрөлжсөн судалгааны эхлэл болжээ.

1991-94 онд Азийн хөгжлийн банкны шугамаар Байгаль орчны яаманд тусгай төсөл хэрэгжүүлжээ.

Бутачийн Лувсанданзан 1946 онд Москвагийн их сургуулийг дүүргэсэн анхны геологийн нэг бөгөөд 1955 онд “Говь-Алтай аймгийн Чандмань сумын геологи, петрографи” сэдвээр геологи-минералогийн дэд эрдэмтэн (Ph. D) болсон анхны эрдэмтэн юм.



**Б.Лувсанданзан**  
**1921-2008)**

Монгол Улсын Шинжлэх ухааны анхны гавьяат ажилтан, шинжлэх ухааны доктор (Sc.D), академич Б.Лувсанданзан бол Монголын анхны геологийн нэг бөгөөд түүний судалгааны ихэнх нь Баруун Монголын геологийн тогтоцыг судлахад чиглэгдэж байв. “Өрнөд Монголын геологи” хэмээх түүний ганц сэдэвт бүтээл Монголын геологийн судалгаанд чухал байр суурийг эзэлдэг.

Тэрээр 1976 онд “Өрнөд Монголын палеозойн атираат бүтцүүд ба боржинлог формац” сэдвээр шинжлэх ухааны докторын (D. Sc) зэрэг хамгаалжээ.

Монгол улсын анхны геологийн зураг 1957 онд академич В.А.Обручевын редакцийн дор 1:2 500 000-ны масштабээр зохиогдон хэвлэгджээ.

Геологийн болон ашигт малтмалын 1:1 500 000-ны масштабын зургууд 1966 ба 1971 онд профессор Н.А.Мариновын редакциар хэвлэгдэв.

1994 онд Монгол улсын 1:1 000 000-ны масштабтай анхны геологийн зургийг доктор (D. Sc) Ж.Бямбын удирдлагын дор, Ц.Махбадар, Б.Дэлгэрцогт, Ө.Жамъяндорж, Д.Чагнаадорж, Ф.Тунгалаг нар зохиосон бөгөөд энэ зургийг 1999 онд академич О.Төмөртоого тэргүүтэй геологчид нэмэлт хийж гаргасан.

Мөн Монгол улсын металлогени, минерагени ба прогнозын, структур-формац, тектоник, гидрогеологийн зэрэг төрөлжсөн зураг, ОХУ ба БНХАУ-ын хилийн дагуух болон Монголын бүс нутгийн геологийн зургуудыг манай үндэсний мэргэжилтнүүд зохион гаргав.

Монгол орны геологийн судалгааны үр дүнгээр зохиогдсон анхны бүтээл нь Н.А.Мариновын “Стратиграфия Монгольской Народной Республики” (1957), Ф.К.Шипулиний редакторласан “Геологическое строение МНР” (1959), Н.А.Маринов, В.Н.Попов нарын “Гидрогеология Монгольской Народной Республики” (1963) хэмээх номууд юм.

ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд болон үндэсний геологийн албаны олон жилийн судалгааны үлэмж их материалыг нэгтгэн дүгнэж 1973-77 онд “Геология Монгольской



**Н.А.Маринов**  
(1914-1996)

Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Николай Александрович бол оорийн ухамсарт амьдралынхаа ихэнхийг Монголын нутаг дэвсгэрийн стратиграф, ашигт малтмал, гидрогеологийг судлахад зориулсан болно. Тэр бээр бол сайн гидрогеологч, сайн геологч байгаад зогсохгүй судалгаа шинжилгээний ажлыг сайн зохион байгуулагч, сурган хүмүүжүүлэгч байсан юм.

Народной Республики” хэмээх 3 боть (I-Стратиграфи, II-Магматизм, тектоник, III-Ашигт малтмал) ном хэвлүүлсэн нь тулгуур бүтээл болсон бөгөөд одоог хүртэл ач холбогдлоо алдаагүй байна.

Монгол оронд хамгийн хүчтэй буюу 10-11 баллын газар хөдлөл 1957 оны 12 дугаар сарын 4-ний өдөр болсон бөгөөд Говийн Алтайн газар хөдлөлт гэж алдаршсан юм. Уг газар хөдлөл Баянцагааны нуруунаас зүүн-урагш Бага богд ба Арц богд хүртэлх өргөн уудам нутгийг хамарчээ. Түүний улмаас янз бүрийн чиглэл, хэмжээ бүхий ангил, хагарлын бүс үүсчээ. Хагарлын хойд бүс нь 320-350 км, өмнөд бүс нь 200-220 км үргэлжлэх бөгөөд 2-оос 7 м хүртэл босоо шилжилт үүсчээ. Газар хөдлөл болсны дараа геологчид болон бусад мэргэжлийн хүмүүс очиж шинжилгээ дүгнэлт хийж, В.А.Бобров, С.Балдан, Н.А.Маринов нар тусгай ном бичиж 1959 онд хэвлүүлжээ. Улмаар А.П.Булмасов тэргүүтэй хэсэг судлаачид “Гоби-Алтайское землетрясение” хэмээх нэг сэдэвт бүтээл (1963) туурвиж уг районы геологийн тогтоц, геоморфологи, неотектоник, геофизикийн шинж чанар, газар хөдлөлийн явц, үр дагавар, ан цав, хагарлын төрөл, газар хөдлөлийн прогноз зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамарчээ. Энэхүү бүтээлийн зохиогчоор манай анхны геологчдын нэг Л.Нацаг-Юм оролцжээ.

Анх 1960-61 оны хичээлийн жилд МУИС-ийн Байгалын ухааны факультетийн бүрэлдэхүүнд геологийн салбарыг нээснээр дотооддоо геологийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлснээс хойш олон мянган дээд боловсролтой ажилтнуудыг төгсгөн гаргажээ.

Одоо ШУТИС болон МУИС-д геологийн мэргэжилтэн бэлтгэхийн зэрэгцээ эрдэм шинжилгээний цуврал бүтээл гаргаж байна. ШУТИС-ийн геологийн сургууль тус орны талбайн судалгаанд оролцож иржээ.

Тэр үеийн МУИС-ийн Политехникийн дээд сургууль Эрхүүгийн Их сургууль, Политехникийн дээд сургуулийн эрдэмтэн багш нар Монгол-Зөвлөлтийн хамтарсан Хөвсгөлийн (1970) болон Хэрлэнгийн (1974) экспедицийг байгуулан ажиллуулж судалгааныхаа үр дүнгээр хэд хэдэн цуврал бүтээл гаргажээ.

Мөн Дарханы политехникумыг техник геологч, өрөмдлөгийн техникч, Чойр, Налайхын техник-мэргэжлийн сургуулийг өрмийн мастер, засварчин, дизельчин зэрэг мэргэжлээр 2000 гаруй хүн төгсчээ.

МУИС-ийг анх 1963 онд С.Базар, Ш.Бизьяа, С.Гажидмаа, Д.Гонгоржав, С.Дашдаваа, З.Жамбал, Х.Казарбек, Г.Равжаа, Д.Самбуу, С.Сономцэвээн, С.Сүхээ, Ш.Тагт, Б.Шаравдорж нарын 13 геологч инженер төгсчээ. Ангийн дарга нь С.Дашдаваа байсан бөгөөд тэрээр хожим доктор, профессор болжээ.

Геологийн бүрэн курсээр 1965 онд төгсөгчид нь Г.Болд, Э.Болд, Д.Дашцэрэн, Ц.Дашцэрэн, В.Дунаев, Ж.Дэнсмаа, Б.Мэндбаяр, Г.Намсрай, Никифорова, З.Нэргүй, П.Нямбуу, Д.Оросоо, Репин, Б.Сандаг, Хонаева, Ч.Хуажин, Ц.Цэдэн, Ч.Ээбум,

В.М.Якимов нар байлаа.

Политехникумын геологийн ангид 1960-64 онд суралцаж төгссөн 26 хүүхэд бол манай анхны техник геологчид юм. С.Алепхан, Г.Балсанжав, Баттөмөр, О.Балчиндорж, Н.Болдбаатар (Алько), Г.Гомбоням, Данзандаржаа, Д.Дашдорж, С.Доржпүрэв, Жанлавцогзол, А.Загд, С.Ламчин, Мөнхнасан, Мягмарсүрэн, Ц.Олзвойбаатар, Б.Очирбат, А.Пүрэв, Д.Пүрэв-Очир, Ц.Ренчиндорж, Ю.Ренчинсэнгээ, С.Санжсугар, Слай, Д.Тогоонацаг, Т.Тогтасын, Цогбадрах, Д.Чулуунбат нар Я.Ширнэн багшийн удирдсан ангийг дүүргэжээ. Тэднээс Г.Балсанжав, Н.Болдбаатар, Г.Гомбоням зэрэг хүмүүс одоо хүртэл геологи, эрдэс баялгийн салбарт ажиллаж байна.

Эрдэс баялгийн музейг анх МУИС-д 1962 онд багш, дэд эрдэмтэн Ж.Лхамсүрэн, ЗХУ-аас уригдан ирсэн мэргэжилтэн багш, доцент К.М.Малкова нарын санаачилгаар минералогийн музей нэртэйгээр байгуулжээ.

Анх голдуу гадаад орнуудын ашигт малтмал, эрдсийн цөөн тооны үзмэртэй байсан бол 1964 оноос эхлэн эх орныхоо эрдэс баялгийн үзмэрийг системтэй цуглуулсанаар одоо эрдэм шинжилгээ, сургалт, танин мэдэхүйн ач холбогдолтой өвөрмөц бүтэц тогтоцтой төрөл бүрийн чулуулаг, томоохон ордуудын хүдрүүд, гоёмсог өнгө талст бүхий ховор нандин эрдсүүдийн 5 000 гаруй дээж үзмэртэй болоод байна.

1963 онд ЭЗХТЗ-ийн 18 дугаар хуралдаанаар Геологийн байнгын комисс байгуулагдсанаар геологийн салбарт ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай хамтран ажиллах нөхцөл бүрдсэн юм. ЗХУ-аас гадна Болгар (1962), Чехославак (1963), Ардчилсан Герман (1965), Польш (1966), Унгар (1966) зэрэг улсуудтай хамтран талбайн зураглал болон алт, зэс, холимог метал, вольфрам, хайлуур жонш, нүүрс, барилгын материал зэрэг төрөл бүрийн ашигт малтмалын эрэл-хайгуулын ажлыг гүйцэтгэсэн байна.

Монгол-Польшийн ШУА-иудын хамтарсан палеонтологийн экспедиц 1963-65 онд говийн районд (Нэмэгт, Баянзаг) ажиллаж мезо-кайнозойн хурдсаас үлэг гүрвэл, яст мэлхий болон хөхтөн амьтны олон тооны үлдвэр олж судалсан байна.

1979 онд “Монголболгарметалл”, “Монголчехославакметалл” үйлдвэр байгуулагдаж алт, зэс, хайлуур жонш, өнгөт чулуу зэрэг ашигт малтмалын ордын хайгуул-ашиглалтын ажил эрхэлж байжээ.

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш манай гадаад харилцаа улам өргөжин Япон, Франц, ХБНГУ, Солонгос, Англи, Австрали, Канад, Америк, Чех, ОХУ зэрэг орнуудтай хамтран ажиллаж байна.

МУИС-ийн геологийн анхны төгсөгч С.Сономцэвээн, Д.Самбуу, Ш.Бизьяа болон Зөвлөлтөд сургууль төгссөн Баяндай нарын инженерүүд бүхий анхны монгол анги 1964 онд Чойрын экспедицийн харьяанд Дорноговийн Дэлгэрэх сумын нутагт Чандмань уулын дүүрэгт зэсийн чиглэлээр ажиллажээ.

Анх 1964 онд Б.Лувсанданзан “Геологийн үндсүүд” сурах бичгийг монгол хэл дээр зохиосон бөгөөд сүүлийн жилүүдэд В.Балжинням, Ж.Лхамсүрэн, Ж.Бямба, Д.Доржготов, А.Пэрлээ, Я.Болд, Д.Гарамжав нарын зэрэг хүмүүс нарийн мэргэжлийн сурах бичиг, гарын авлага зохион хэвлүүлээд байна.

“Геологийн нэр томъёоны товч тайлбар толь”-ийг анх 1966 онд Ш.Цэвэг эмхэтгэж, П.Хосбаяр редакторлан гаргажээ. 1991 онд “Геологийн түгээмэл нэр томъёоны орос-монгол толь”-ийг Г.Жамсрандорж, Д.Гарамжав, Ж.Лхамсүрэн нар эмхэтгэн гаргав.

Улмаар 1994 онд “Геологийн нэр томъёоны орос-монгол-англи толь”-ийг (8000 орчим үгтэй) Ө.Жамьяндорж, Ж.Бямба, Г.Жамсрандорж, Д.Гарамжав нар эмхэтгэн боловсруулан хэвлүүлж нийтийн хүртээл болгожээ. Уг тольд автохтон- суугуул,

аллохтон- нүүгүүл, грабен- ховдол, горст- гүвдэл, комплекс- бүрдэл зэрэг шинэ хэлц, шохойн чулуу- шохойжин, элсэн чулуу- элсжин зэрэг шинэчилсэн нэр томъёог олноор оруулжээ

Эрдэнэтийн овооны зэс-молибдений ордын хайгуулын анхны цооногийг Хөвсгөлийн геологийн удирдах газрын өрмийн мастер Х.Цэвэгжав өрөмджээ.

Оюу толгойн ордын анхны 6 цооногийг "Говьгео" компанийн монгол өрөмдөгчид 1997 оны 9 дүгээр сард өрөмджээ.

1966 онд МАХН-ын Улс төрийн Товчооны 113 дугаар тогтоолоор Шинжлэх ухааны Академи ба Геологийн яамны харьяа Геологийн хүрээлэн (анхны захирал нь Маамжавын Цэрэндорж) байгуулсан нь салбарын анхны эрдэм шинжилгээний байгууллага юм.

Үүнээс өмнө уг ажлыг Судар бичгийн хүрээлэнгийн газар зүйн тасаг хариуцаж байсан ба 1938 онд геологийн секцийг тасаг болгон өргөтгөжээ.

1974 онд анх яамны дэргэд Геологи, уул уурхайн үйлдвэрлэл-шинжилгээний институтыг (захирал нь Чимидийн Ээбум) байгуулсан бөгөөд үүнээс өмнө Нэгдсэн сэдэвчлэх анги (1971) нэртэй ажиллаж байв.



**Ч.Ээбум**  
(1930-1987)

Ч.Ээбум бол дотоодод геологийн мэрэгжил эзэмшсэн геологчидоос хамгийн түрүүнд геологи-минералогийн ухааны докторын (PhD) зэрэг хамгаалсан бөгөөд Геологи, уул уурхайн үйлдвэр-шинжилгээний хүрээлэнгийн анхны захирлын алба хашиж байв. Түүний судалгааны ажил нь мезозойн нүүрсний ордын зүй тогтолыг судлахад чиглэгдэж байв.

Монголын геологийн судалгааны үр дүнгээр хэвлэгдсэн ном, өгүүллийн тоймыг эмхэтгэн "Геологические исследования Монгольской Народной Республики" номыг анх 1967 онд Н.А.Маринов хэвлүүлжээ.

Түүнд ХҮШ зууны сүүлчээс 1964 оныг хүртэлх 968 бүтээлийн реферат хамрагдсан бол 1971 оны Б.Н.Ерофеев, Н.А.Мариновын номд 1965-68 оны 255 бүтээлийн, 1989 оны Н.А.Мариновын номд 1969-73 оны 474 бүтээлийн реферат оржээ.

Эдгээр нь Монголын геологийн судалгаа, түүний үр дүнгийн талаархи чухал лавлах болсон юм.

Анх 1967 онд ЗСБНХУ ба БНМАУ-ын ШУА-уудын хэлэлцээрийн дагуу Зөвлөлт-Монголын геологийн эрдэм шинжилгээний хамтарсан экспедиц (Ерөнхий куратор А.Л.Яншин, Зөвлөлтийн талын дарга Н.С.Зайцев, Монголын талын дарга М.Цэрэндорж, Б.Лувсанданзан) байгуулагдан стратиграфи, геологи-геоморфологи, тектоник,



**Н.С.Зайцев**  
(1911-1992)

Доктор (PhD) тэр бээр Монгол-Зөвлөлтийн геологийн хамтарсан экспедицийн зөвлөлтийн талын даргаар 1967-1992 онд ажилласан бөгөөд Алтай-Саяны атираат мужийн геологийг сайн мэддэг гарамгай эрдэмтэн байсан юм.

петрологи-геохими зэрэг чиглэлээр ажиллажээ. Улмаар 1969 онд палеонтологийн хамтарсан экспедицийг байгуулжээ. Эдгээр экспедиц нь 100 гаруй цуврал бүтээл гарган манай орны регионал судалгаанд жинтэй хувь нэмэр оруулсан юм.

Хайгуулчдын дотроос анх Монгол улсын Хөдөлмөрийн баатар цолыг 1969 онд Хөвсгөлийн геологийн экспедицийн өрмийн мастер Лантуугийн (Өлзийбатын) Сэрчиндорж хүртжээ.

Одоогийн байдлаар уг цолоор өрмийн ахлах мастер Н.Нямдорж, Ж.Сүрэнхүү, У.Буянбаатар нар шагнагдаад байна.

Аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолыг анх 1976 онд Улаанбаатарын геологийн удирдах газрын өрмийн ахлах мастер Доржийн Цэвлээ хүртжээ.

Түүнээс хойш өрмийн мастер Б.Жамц, Ш.Цогвоо, Г.Базаррагчаа, геологч Д.Тогтох, Л.Мөнхтоого, Т.Сэнгээ, Д.Гарамжав нар уг цолоор шагнагджээ.

Дуламын Тогтох нь аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор шагнагдсан анхны мэргэжлийн геологч бөгөөд манай орны талбайн геологийн судалгаанд ихээхэн хувь нэмэр оруулсан хүн юм.

Ж.Дүгэрсүрэн нь 1971 онд “БНМАУ-ын нүүрсний ордуудын геологи, түүний зүй тогтол” сэдвээр зэрэг хамгаалсан манай шинжлэх ухааны анхны доктор (D. Sc) юм. Тэрээр 1961 онд дэд эрдэмтний (Ph. D) зэрэг хамгаалжээ.

Геологийн салбар одоогийн байдлаар шинжлэх ухааны доктор 13-тай болоод байна. Тэднийг нэрлэвэл: Ж.Дүгэрсүрэн (1971), Б.Лувсанданзан (1976), Р.Барсболд (1979), Д.Дашзэвэг (1985), Ж.Лхамсүрэн (1989), О.Төмөтоого (1989), Д.Доржнамжаа (1990), Ж.Бямба (1991), О.Гэрэл (1991), Д.Бат-Эрдэнэ (1993), Н.Батсүх (1995), Н.Жадамбаа (1997), Л.Дүгэржав (2001) нар юм.



**О.Төмөртоого**  
(1939 онд төрсөн)

Монголын академч тэр бээр Монголын геологийн өнгөрсөн цаг үеийн ороген, офиолит болон далайн төрлийн царцдасыг сэргээн босгох, геодинамикийн хөгжил зэрэг тектоникийн өргөн хүрээтэй асуудлаар ажиллахын хамт Монголын геологийн зураг зүйг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмрээ оруулж байгаа юм.

МУИС төгсөгчдөөс анх Чимэдийн Ээбум эрдэмтэн болжээ. Тэрээр 1972 онд “Монголын нутагт үүсвэрлэсэн мезозойн эриний нүүрсний ордууд ба түүнийг ашиглах хэтийн төлөв” сэдвээр боловсролын докторын зэрэг хамгаалсан бөгөөд яамны харьяа институтийг он удаан жил удирдаж байлаа.

Геологчдын дотроос анх 1973 онд Төрийн соёрхол хүртсэн хүмүүс бол Эрдэнэтийн овооны ордын хайгуулын ажилд биесчлэн оролцсон Лувсангийн Мягмар, Гүндсамбуугийн Сандуйжав нар юм.

1986 онд Хойт Хэнтий, Заамарын алтны геологи хайгуулын ажилд хувь нэмрээ оруулсан Дарханы геологийн экспедицийн геологч С.Цэрэн-Очир, С.Гомбосүрэн, В.Довжид, Д.Гунгааням, өрмийн мастер Т.Баяраа нар Төрийн соёрхол хүртжээ.

1973-75 онд Өвдөг худагийн нүүрсний сав газарт зураглалын зориулалттайгаар доод цэрдийн хурдаст Н.Нямдоржийн удирдлагаар Д.Цэвлээ нар 1024 м өрөмдсөн нь монголчуудын өрөмдсөн хамгийн анхны гүн цооног юм. Уг цооногийн бичиглэлийг доктор П.Хосбаяр хийсэн нь доод цэрдийн хурдсын зүсэлтэд тодорхой байр эзэлнэ



Шинэ олдворын шагналыг анх 1975 онд Архангайн Шаварын царамын анарын ордыг нээсэн С.Мөнхтогтох, Т.Намсрай, Ш.Олзвой болон Шүдэн уулын жамц давсны ордыг нээсэн Ж.Сумьяа нарт олгожээ. Түүнээс хойш цөөн хүнд олгоод сүүлдээ олгохоо больжээ.

Өмнөговь аймгийн нутаг дахь Оюу толгойн алт, зэсийн томоохон ордыг илрүүлсэн явдал нь хайгуулчдын зүй ёсны бахархал юм. Уг орд нь урьд өмнө мэдэгдэж байсан боловч 1996 онд геологч Д.Гарамжав (аж үйлдвэрийн гавьяат ажилтан), Т.Мөнхбат, америкийн геологч Д.Кокс нар судлан хайгуул хийх санал дэвшүүлсэн тул анхлан нээгчээр зүй ёсоор тооцогддох юм. Дондогийн Гарамжав Канад улсаас олгодог олон улсын олдворын шагналын анхныхыг 2004 онд хүртжээ

Дожир, Хар ямаат зэрэг ордын хайлуур жоншийг 1930-аад оны сүүлчээр зөвлөлтийн мэргэжилтнүүдэд мэдээлсэн Бэрх нэртэй газарт амьдарч байсан нутгийн ард Санжаа нь шинэ олдворын эздийн анхдагч байжээ. Түүний мэдээллийн дагуу геологи хайгуулын ажил хийгдэж 1953 онд Бэрхийн (Санжаагийн) уурхай нээгдсэн байна.

Цагаансуваргын зэсийн ордыг 1963 онд нутгийн ард Насандэлгэрийн мэдээллээр геологч Ч.Хурц илрүүлсэн ажээ.

Анхны Олон улсын экспедицийг Монголд байгуулах саналыг Ж.Бямба гаргаж 1976 онд ЭЗХТЗ-ийн гишүүн 9 орны оролцоотойгоор (анхны дарга нь доктор Ж.Бямба) байгуулагдаж Умард Хэрлэн ба Өмнөд Говьд ховор металл, зэс, алт, хайлуур жоншны хүдэржилтийн бүсэд талбайн зураглал, ерөнхий эрэл, эрэл-үнэлгээ болон хайгуулын ажлуудыг амжилттай гүйцэтгэн Өндөрцагаан, Хөлийн холбоо зэрэг 70 орчим орд, илрэлийг нээж судалгааныхаа үр дүнгээр 3 цуврал бүтээл хэвлүүлжээ

Очирын Гэрэл бол манай ууган эмэгтэй эрдэмтэн юм. Тэрээр 1978 онд боловсролын, 1990 онд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалжээ.



О.Гэрэл  
(1941 онд төрсөн)


Проф. Гэрэл нь Монголын анхны эмэгтэй эрдэмтэн геологч юм. Түүний судалгааны ажил нь петрологи, геохими, хүдэржилтэнд чиглэгдэж иржээ. Түүнээс гадна тэр бээр Монгол улсад геологийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, петрологийн судалгааны суурь тавихад үнэтэй хувь нэмрийг оруулсан Монголын шинжлэх ухааны гавьяат ажилтан юм.

Хамгийн залуудаа буюу 44 настайдаа Ринченгийн Барсболд 1979 онд “Монгол орны цэрдийн галавын үлэг гүрвэл” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг (Sc.D) хамгаалжээ. Тэрээр 1969 онд “БНМАУ-ын говийн хэсгийн дээд цэрдийн давхарга зүй ба цэнгэг усны нялцгай биетэн” сэдвээр боловсролын доктор болжээ.

Салбарын эрдэмтэд дотроос академич цолыг анх 1982 онд Б.Лувсанданзан хүртжээ. Академич цолыг одоогоор 1991 онд Р.Барсболд, Д.Дашзэвэг, О.Төмөртоого нар хүртээд байна.

Ахмад геологч Харчууд овогт Өвгөнхүүгийн Жамьяндорж анх 1982 онд “Дэлхийн тухай өгүүлэх нь” геологийн шинжлэх ухааны хялбаршуулсан зохиол бичиж нийтийн хүртээл болгожээ. Тэрээр мөн “Чулуун модны гайхамшиг”, “Хүн ба чулуун мандал”, “Газар дэлхийн товч түүх” нэртэй номуудыг бичиж хэвлүүлжээ.

Зөвлөлт, монголын мэргэжилтнүүдээс бүрдсэн анхны бүлэгчилсэн зураглалын анги манай улсад 1974 оноос ажиллаж байлаа.



**Р.Барсболд**  
(1935 онд төрсөн)

Шинжлэх ухааны гавьяат ажилтан, доктор (Sc.D) Р.Барсболд нь Монголын үлэг гүрвэлийн аймгийн ангилал, удам төрлийн холбоо, тив хоорондын харилцааг тогтоохоор явуулж ирсэн судалгааны үр дүнд, уг аймгийн үүсэл хөгжил, дэлхий дахинд эзэлж байсан байр суурь, ач холбогдол нь тодорсоор ирэв. Үүний үр дүнд Монгол улс нь үлэг гүрвэлийн судалгаагаар дэлхийн тэргүүлэх орнуудын нэг болохыг харуулсан юм.

Анхны монгол мэргэжилтнүүдээс бүрдсэн 1:200 000-ны масштабын бүлэгчилсэн зураглалын Гурвансайханы анги (дарга Ц.Баатар, ерөнхий геологч Д.Тогтох) 1982-84 онд Өмнөговь, Өвөрхангай, Дундговь аймгийн нутгийг хамарсан 49,8 мянган кв. км талбайд хийжээ.

Монгол орны нутаг дэвсгэр 1:200 000-ны масштабтай талбайн геологийн зураглалын ажлаар 2000 оны орчимд үндсэндээ бараг бүрэн бүрхэгдэж дууссан бөгөөд энэ нь Улсын хэмжээний тоон мэдээлэлтэй 1:200 000-ны Улсын геологийн иж бүрдэл зураг зохиох төслийг эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн юм. Уг зургийн анхны ерөнхий редактор Ж.Бямба ажиллаж байв. Монгол Улсын геологийн судалгааны цоо шинэ үе болох “УГЗ-200” төслийг анхлан 2001 онд зохион байгуулж эхлүүлэн одоо хүртэл ажиллаж байгаа хүн бол эрдэмтэн, геологч Балжиннямын Дэлгэрцогт юм. Тэр 1:50 000-ын масштабын геологийн зураглал, ерөнхий эрдмийн ажлыг явуулах “ЗААВАР”-ыг монгол хэл дээр мөн анх удаа боловсруулж гаргасан.

Гадаад оронд монголоос мэргэжилтнээр ажилласан анхны геологчид нь БН Куба улсад 1983 оноос ажилласан Б.Баярхүү, Ж.Амгаа нар юм. Дөрвөн жилийн дараа мөн тэнд Т.Захай, В.Уртнасан нар очиж ажиллажээ.

Монгол улсын шинжлэх ухааны анхны нээлтийг академич Б.Лувсанданзан Зөвлөлтийн эрдэмтдийн хамт “Ховор металл боржин дотор ховор элементүүд ба хөнгөн цагааны ялгарах, хуримтлах үзэгдэл” бүтээлээр 1985 онд хийж 01 тоот диплом авчээ.

Эх газарт бүрэн хэмжээгээр хадгалагдан үлдсэн офиолитийн зүсэлтийг Л.П.Зоненшайн, М.И.Кузьмин нар 1976 онд Хантайширын дүүрэгт анх удаа тогтоож, улмаар офиолит бол өнгөрсөн цаг үеийн далайн плитийн үлдэц болохыг баталсан юм.



**Л.П.Зоненшайн**  
(1929-1992)

Оросын шинжлэх ухааны академийн сурвалжлагч гишүүн Л.П.Зоненшайн нь эх газрын ба далайн геологийг ижилхэн судалсан. Тэрбээр дэлхийд нэртэй эрдэмтэн байсан юм. Монголын тектоникийн хөгжлийн зүй тогтлыг плит тектоникийн үүднээс тайлбарласан анхны эрдэмтэн юм.

Геологчоос эдийн засагч болж улмаар эрдмийн зэрэг хамгаалсан анхны хүн бол Аюушжавын Баасанжав бөгөөд тэрээр орлогч сайдын (1983-88) албыг хашиж байжээ. “Монголын хайлуур жоншны орд газруудын геологи-эдийн засгийн үнэлгээ” сэдвээр 1978 онд эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалсан байна.

Манай геологчид уурхайчид, эдийн засагчид 1972 оноос эхлэн эрдэс баялагийн

эдийн засгийн үнэлгээг бие даан хийдэг болсон. Энэ ажилд Г.Дорж, Ш.Содномцэрэн, Жигмэд Очир, С.Авирмэд зэрэг хүмүүс идэвхтэй оролцож ирэв. Эхний үед энэ ажлыг хөл дээр нь босгоход зөвлөлтийн геологч О.Лисневский зөвлөж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Техник геологчоос инженер геологч, улмаар доктор болсон анхны хүмүүс бол Р.Баттөмөр (1986), Г.Ухнаа (1990), П.Шаандар (1992), У.Борчулуун (1994) нар юм. Харин дунд мэргэжилтнээс дээд мэргэжил эзэмшсэн хүмүүс олон бий

1992 оны шинэ үндсэн хуулийг батлалцсан ховорхон хувь тавилантай хүмүүс бол Ч.Хурц, Д.Чилхаажав нар юм.

Доктор Чойжингийн Хурц нь Геологийн яамны орлогч сайд, сайд зэрэг хариуцлагатай албыг хашиж салбарын хөгжилд ихээхэн хувь нэмрээ оруулсан билээ.

Д.Чилхаажав Улсын бага хурлын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан анхны геологч бөгөөд Ардчилсан холбооны анхны гишүүдийн нэг юм.

Геологчдын дотроос Ч.Хурцаас гадна УИХ-ын гишүүнээр С.Оюун, Д.Одхүү нар сонгогдон ажиллаж байна.

Дашрамд дурдахад 1990 оноос өмнө Ардын Их Хурлын депутатаар өрмийн мастер Н.Нямдож, Г.Базаррагчаа нар сонгогдож байжээ.

Профессор цолыг анх манай ууган төгсөгчдийн нэг доктор (Ph. D) Самдангийн Дашдаваа 1993 онд хүртсэнээс хойш ШУТИС, МУИС-ийн 20 гаруй багш нар уг цолыг хүртээд байна

Анхны “Ашигт малтмалын тухай” Монгол улсын хуулийг 1995 онд баталсан бөгөөд 1997 ба 2006 онуудад шинэчилжээ.

МУИС-ийн багш, доктор, профессор Алтангэрэлийн Пэрлээ газар уснаа оршин амьдарч байсан холимог идэшт амьтдын бүлэг “Сегнозавр” гэгчийг анх нээсэн бөгөөд Монгол орноос цоо шинээр олдсон үлэг гүрвэл ба шувуу хоёрын завсрын шинжийг хадгалсан амьтны судалгааг хийсний дүнд нэгэн төрлийн махчин гүрвэлээс нисдэггүй шувууны удам (Мононикас) үүсчээ гэсэн дүгнэлтэд хүрчээ. Үүгээрээ 2002 онд Английн Кембрижийн их сургуулийн Эзэн хааны нэрэмжит коллежийн алтан медаль хүртэж, 21 дүгээр зууны шилдэг эрдэмтнээр тодорчээ. Тэрээр үлэг гүрвэлийн 7 зүйлийг шинээр нээсэн байна.



А.Пэрлээ  
(1945 онд төрсөн)

Доктор PhD. А.Пэрлээ нь Монгол улсад үлэг гүрвэл судлах ажилд үйл ажиллагаагаа зориулсан палеонтологч бөгөөд нийт 7 зүйлийн үлэг гүрвэлийг шинээр нээжээ. Үүгээрээ Английн Кембрижийн их сургуулийн Эзэн хааны нэрэмжит коллежийн алтан медал хүртэж 21-р зууны шилдэг эрдэмтнээр тодорчээ. Түүний туурвисан эрдэм шинжилгээний ажлуудаас “Flightless bird-mononykus Perle at al” дорвитой байр суурийг эзэлдэг

Геологийн тэнхим анх 1961 оны 1 дүгээр сард Ж.Дүгэрсүрэн, Ж.Лхамсүрэн, Р.Барсболд, ЗХУ-ын мэргэжилтэн К.М.Малкова, Ф.В.Пекун нарын бүрэлдэхүүнтэй байгуулагдсан цагаас одоог хүртэл багшилж байгаа Жаргалын Лхамсүрэн анх 2003 онд Монгол улсын гавьяат багш цолоор шагнагджээ. Мөн уг цолоор доктор, профессор Н.Батсүх шагнагдсан байна.

Чойрын геологийн экспедиц, “Говьгео” компанид он удаан жил ажиллаж бүс



**Ж.Лхамсүрэн**  
(1935 онд төрсөн)

Доктор (ScD), профессор, гавьяат багш Ж.Лхамсүрэнгийн үйл ажиллагаа нь голдуу залуу боловсон хүчнийг сурган хүмүүжүүлэхэд чиглэгдэж ирсэний хамт Монгол орны ашигт малтмалын ордын геологи түүний дотор гененик минералогийн ба хайлуур жонш, өнгөт эрдэнийн чулууны чиглэлийг хөгжүүлэхэд үр бүтээлтэй ажиллаж байгаа болно.

нутгийн геологийн судалгаанд ихээхэн хувь нэмэр оруулсан геологч С.Мягмар агсны дурсгалд зориулан Үнэгтийн ховдол дахь ураны нэгэн ордыг түүний нэрээр нэрлэсэн нь анхных юм.

Академич Р.Барсболд, Д.Дашзэвэг, доктор Ч.Минжин, Г.Ээнжин нарын зэрэг хүмүүс янз бүрийн амьтдын олон тооны шинэ төрөл зүйлийг илрүүлж литостратиграфийн нарийвчилсан ангилалыг баталгаажуулахад чухал хувь нэмэр оруулсан бөгөөд тэдний нэрээр нэрлэгдсэн зүйл хэд хэд бий.

Алтаар баян манай орны хамгийн том буюу 808 грамм жинтэй цул төрц анх 1995 онд Заамарын Хайлаастын ордоос олджээ.

Горхийн Хар ямаат гэдэг газраас анх болорын тус бүр 2,5; 7; 9 тонн жинтэй аварга том талст олдож байсан нь Монголд төдийгүй дэлхийд ховорхон олдвор юм.

Мөн Архангайн Шаварын цармаас бараг зангидсан гарын дайтай анарцэнт (пироп, алмаасыг дагалдагч эрдэс) олдсон мэдээ бий. Тэрээр дэлхийд олдсон нэг том



**Д.Дашзэвэг**  
(1936 онд төрсөн)

Монгол улсын академич, геологийн-минералогийн шинжлэх ухааны доктор тэр бээр Монголын хөхтөн амьтадын ангилал, морфологийн талаар жинтэй судалгаа явуулснаас гадна тэдгээрийн тив хоорондын харьцуулалт хийж дэлхийн жишигт хүргэсэн байна.

анарцэнт байж болох юм.

Харамсалтай нь тэдгээр олдвор одоо хаана байгаа, эсэх нь тодорхойгүй болжээ.

Монгол орны нутаг дэвсгэр дэх хамгийн эртний чулуулаг болох неоархейн мигматит-саарал гнейсийн бүрдлийг Баянхонгорын Байдраг орчимд илрүүлэн 2646+-45 сая жилийн настай (Ф.П.Митрофанов, 1985) болохыг цирконд изотопын (уран-хар тугалганы) аргаар тодорхойлжээ

Хуучнаар венд ба доод кембрийн тасралтгүй зүсэлтийг Говь-Алтай аймгийн нутаг дахь Баянголд тогтоосон бөгөөд тэнд хоёр эратем буюу протерозой болон палеозойн заагийг амьтны үлдвэрээр багтай тогтоосон нь хроностратиграфийн ангилалд чухал ач холбогдолтой юм.

Уг зүсэлтийг анх В.В.Беззубцев хийсэн бөгөөд хожим 1996 онд В.В.Хоментовский нар түүнийг нарийвчлан дээрх хил заагийг бичил фауны олдвороор тогтоожээ.

Геологчдоос аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолыг анхлан хүртсэн Д.Тогтох нь хээрийн үйлдвэрлэлд тасралтгүй хамгийн удаан (37 жил) ажилласан, хамгийн том (160 орчим мянган кв. км) талбайг судалсан, хамгийн олон (14, үүнээс 8 тайлангийн гол

зохиогч, 6 тайлангийн хамтран зохиогч) тайлан бичсэн хүн юм.

Төрийн албанд тасралтгүй 38 жил ажилласан геологч нь Банзрагчийн Бэгзсүрэн бол төрийн захиргааны төв байгууллагад Борнойн Амарсайхан 1982-2009 онуудад ажиллажээ.

Шинжлэх ухааны доктор, профессор Лхамсүрэнгийн Баярмандал 2007 онд “Хантайширын офиолит эвшлийн геохими, петрологи ба гарал үүсэл” сэдвээр боловсролын докторын зэрэг хамгаалан удам дамжсан анхны эрдэмтэн болжээ.

Хамгийн залуудаа буюу 28 настайдаа Сэржлхүмбийн Амар-Амгалан 2008 онд боловсролын доктор болсон нь манай эрдэмтэд залуужиж байгааг харуулж байна.

Түүнээс өмнө 1989 онд Л.Баярбилэг 31-тэйдээ, 1972 онд Ж.Бямба, П.Хосбаяр, 1981 онд Ч.Минжин нар 32-тойдоо дэд эрдэмтэн болсон байна.

Ордыг нээж хайгуулыг нь хийж, олборлож байгаа, улмаар эрдмийн зэрэг хамгаалсан анхны геологч нь Дархижавын Эрдэнэ юм. Тэрээр 2008 онд судалгааны ажлынхаа үр дүнгээр “Хавцалын хайлуур жоншны ордын геологи-минералогийн онцлог ба гарал үүсэл” сэдвээр докторын (Ph. D) зэрэг хамгаалжээ.

Манай хайгуулчдаас анх 2008 онд Антарктид тивд доктор Л.Дүгэржав очиж тодорхой судалгаа, ажиглалт хийжээ

Ахмад геологч Лхамсүрэнгийн Мягмарсүрэн бол Монголын шатарчдаас анх удаа Олон улсын мастер, гавьяат тамирчин цол хүртсэн хүн юм.

Мөн геологчдоос Дэлхийн шатрын холбооны мастер Н.Төвсанаа, Монгол улсын спортын мастер Г.Гунгаабазар, Т.Төгөлдөр, С.Нордод нар болон олон арван сайн шатарчид төрөн гарчээ.

Эндээс үзэхэд геологчид оюуны чадавхи сайтай хүмүүс юм

Геологчид тал бүрийн авьяастай хүмүүс байдаг. Тэдний дотроос Төрийн соёрхолт, Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч Д.Батбаяр, дуучин Д.Машлай, сэтгүүлч Н.Өлзийбат нараас гадна спортын мастерууд олноор төрөн гарчээ.

Тухайлбал, 100 буудалт даам- Т.Пүрэвдорж, Н.Эрхэмбаатар, үндэсний сур-Гэнэн, А.Санжмятав, дугуй- С.Пүрэвдорж, буудлага-Ж.Ган-Очир, бокс-Т.Ренчиндорж, пирамид бильярд- Д.Эрдэнэ, Э.Болорхүү (хүү, улсын 3 удаагийн аварга) хөл бөмбөг-Бүрэнбадрах, волейбол- Мөнхцогт, Алтанцэцэг нар болон үндэсний бөхийн улсын засуул Х.Пүрэв, М.Батбаяр, Г.Шарав, улсын гарын даа Д.Баянжаргал, С.Сэлэмбаатар нар төрөн гарчээ.

Доктор А.Пэрлээ “Үлэг гүрвэлийн мөрөөр” нэртэй шинжлэх ухааны 2 баримтат киноны зохиолыг бичиж тайлбарыг монгол, англи хэл дээр уншжээ.

Мөн ахмад геологч Н.Жанлав, Ж.Сумьяа, Д.Миеэгомбо нар роман бичиж хэвлүүлжээ.

Геологчдоос Д.Сэсрэн, З.Нарангэрэл, Д.Тогтох, А.Пэрлээ, Д.Пунцагдэлэг, Ш.Батжаргал, Д.Санжаадорж, Д.Аюуш, Ж.Баатар, Б.Баасан, О.Гунгаадорж, С.Хэнзий гээд шүлэг зохиол оролддог хүмүүс олон бий.

Ө.Жамьяндорж “Миний аав” гэдэг шүлэг бичин Залуучуудын үнэн сонины 1968 оны 1 дүгээр сарын 21-ний дугаарт хэвлүүлсэнд Сүхбаатар аймгийн Соёлын ордны хөгжимчин Цоггэрэл ая хийж дуу болсноос хойш 40 жил ард үүмний дунд дуулагдсаар байна.

Геологчдын ажил амьдралыг харуулсан Ч.Лодойдамбын “Алтайд”, Ж.Пүрэвийн “Ундрах инженер” хэмээх роман хэвлэгдсэн бөгөөд хэд хэдэн тууж, өгүүллэг, шүлэг, дуу, кино зохиогдсон байна.

“Ундрах инженер” романыг геологч Энхцэцэгийн ажил, амьдралаас сэдэвлэн бичжээ.

Манай удам дамжсан анхны геологч нь Дүгэрсүрэнгийн Билэгт юм. Ахмад геологч Ж.Лхамсүрэн, Ч.Ээбум, Ч.Минжин, Я.Болд, Д.Доржнамжаа, Д.Товуудорж, Ц.Махбадар, С.Мөнхтогтох, Төмөрсүх, Г.Болд, Г.Дорж, П.Дугараа, Д.Тогтох, С.Цэвээннамжил, Х.Сүхбаатар, С.Гомбосүрэн, Цагаалай, Д.Дашцэрэн (Баянхонгорын) Өндөрнасан, А.Маргай, М.Чулуундорж, Ж.Банзрагч, Чойжамц, Ж.Даваасүрэн, Б.Дамдинжав, Б.Энхбаяр, Д.Гарваа, Ш.Даваа, С.Дандар, Д.Гунгааням, С.Цэрэн-Очир, Д.Санжаадорж, Д.Чагнаадорж, Ш.Баасандорж, Ш.Лхүндэв, Доржсүрэн, Ж.Тогтох, Цэрэнпунцаг, Д.Эрдэнэ, Эрдэмбат зэрэг хүмүүс мэргэжлээ үр хүүхэддээ өвлүүлэн удам дамжсан 2 дахь үеийн геологчид төрөн гарсаар байна.

Зураглал- Д.Тогтох, Ш.Лхүндэв, геологийн эдийн засаг- С.Аюур, С.Авирмэд, А.Баасанжав, Ш.Содномцэрэн, Б.Адьяа, нүүрс- Ж.Дүгэрсүрэн, Ч.Ээбум, Д.Бат-Эрдэнэ, Л.Мөнхтоогоо, Д.Даншцэрэн, Р.Миземхан, А.Дамиран, Н.Авид, алт-Г.Дэжидмаа, Т.Семейхан, Г.Жамсрандорж, Г.Дорж, Ж.Цэнд-Аюуш, зэс-Д.Гарамжав, Б.Гантөмөр, ховор метали- Д.Сэнгээ, Ц.Гүндсамбуу, Б.Батхүү, Н.Чимид, холимог метали- Д.Доржготов, Ц.Цэдэн, хайлуур жонш-Ц.Самбалхүндэв, Б.Түмэнбаяр, Д.Эрдэнэ, рашаан- З.Нарангэрэл, Н.Лхагваа, металл бус ашигт малтмал- П.Шаандар, Б.Бэгзсүрэн, С.Алтангэрэл, Л.Борис, О.Хонгор, Д.Сахьяа, давс- Ж.Сумьяа, өнгөт чулуу-С.Мөнхтогтох, Т.Намсрай гээд тухайн ашигт малтмалаар дагнан тууштай ажиллаж түүнийхээ үр дүнд гавьяа шагнал, зэрэг цол хүртсэн геологчид олон бий.



Г.Бадарч  
(1948-2006)

Доктор (PhD) түүний судалгаа нь Монголын тектоник, стратиграфи, металлогенийн өргөн хүрээтэй асуудлыг хамарч байсны дотор Өмнөд Монголын геологийн тогтоцыг судлахад гол анхаарлаа чиглүүлж байв. Тэрбээр Монголын анхны террейн тектоникийн зураг зохиосон юм.

Томоохон бүс нутгийн тектоникийн тогтоцын талаар сүүлийн үед гарсан онолын суллагааны шинэ чиглэлийг Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд сурталчилах, тайлбарлах чиглэлээр доривтой бүтээл хийсэн эрдэмтэдийн тоонд О.Төмөртогоо, Ж.Бямба, Г.Бадарч нар зүй ёсоор орно.

Мөн нүүрсний Дашцэрэн, Авид, алтны Дэжидмаа, жоншны Эрдэнэ, давсны Сумьяа, рашааны Нарангэрэл, өнгөт чулууны Намсрай, зураглалын Лхүндэв гэхчилэн бараг мэргэжлээрээ овоглогдсон хүмүүс ч бий.

Бид ер нь анхны хүмүүсээ, анхны байгууллагаа, анхны үйл явдлаа, анхны үр дүнгээ хэр зэрэг мэддэг сэн билээ? Энэ талаар бичиж үлдээсэн нь ямар сан билээ?

Өөрт олдсон баримтын хэмжээнд түүчээнүүдийг түүвэрлэсэн тул алдсан, дутуу дулимаг орхисон зүйл байж болохыг болгооно уу.

Маргаантай асуудал байхыг үгүйсгэхгүй бөгөөд засч залруулах талаархи саналаа тодорхой баримттайгаар ирүүлэхийг хүсч байна.

Салбарынхаа түүчээнүүдийг тодруулах гэж олон хүнтэй уулзаж, ном сэтгүүл эргүүлж, нэлээд цаг зарцуулсан боловч бүрэн төгс болж чадсангүй. Тэр талаар баттай баримт сэлт хомс байна. Түүх маань бүдгэрсээр л байна уу даа гэсэн харуусал бас төрж

байна.

Түүх үргэлжилж, геологийн салбар хөгжиж, судалгааных нь ач холбогдол нэмэгдсээр байгаа болохоор түүчээнүүд хойшид ч төрсөөр, тодорсоор байх болно.

Тэгээд ч геологчдоос Монгол улсын Хөдөлмөрийн баатар төрнө. Орд нээсэн гавьяатай геологчид бий болно. Биеэ даасан Геологийн яам байгуулагдана гэдэгт огт эргэлзэхгүй байна.

Эх орныхоо геологийн тогтоц, эрдэс баялгийг шинжлэх ухаанчаар судалдаг геологчдын аяны зам өлзийтэй, ганзага дүүрэн олзтой, алдар нэр нь дуурсаж байх болтугай!